



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 171

Улаанбаатар хот

Г “Дорноговь АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Дорноговь АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Гүйцэтгэх захирал У.Баярбилэгтэй байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2.“Дорноговь АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал У.Баярбилэгтэй Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

3.“Дорноговь АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган биелүүлж, 2023 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт “Сайн” гэж дүгнэгдсэн тул Гүйцэтгэх захирал У.Баярбилэгт хавсралтад заасны дагуу урамшуулал олгосугай.

4.Гүйцэтгэх захирал У.Баярбилэгт хавсралтын дагуу олгох урамшууллыг холбогдох эх үүсвэрээс гаргахыг “Дорноговь АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Ерөнхий нягтлан бодогч Б.Тунгалагтуяад зөвшөөрсүгэй.

5.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001302

11-r huraldaan.docx

Төрийн өмчийн болдого зохицуулалтын газрын  
2024 оны 04 дугаар сарын 18-ны өдрийн  
17 дугаар тогтоолын хавсралт

"ДОРНОГОВЬ АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛД  
2023 ОНЫ АЖЫЛЫН ҮР ДҮНГЭЭР ОЛГОХ УРАМШУУЛАЛ

Д/Д	Хуулийн этгээдийн нэр	Гүйцэтгэх захирын нэр	Цэвэр ашиг /төг/	Цэвэр ашигийн дунгээс хасаж тооцох вагийн ханшийн өөрчлөлтөөс олсон ашиг алдагдал /төг/	Урамшуулалт тооцох цэвэр ашиг /төг/	Олгох урамшууллын хэмжээ /төг/
1	"Дорноговь АЗЗА" ТӨХК	У.Баярбилэг	149,754,450.00	0.0	149,754,450.00	7,995,089.00 (Долоон сая, есөн зуун ерэн таван мянга, наян есөн төгрөг)